



**НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 15 өдөр

Дугаар Б/36

Улаанбаатар хот

┌ Япон улсын “Саппоро-2025” олон
улсын марафон гүйлтийн үйл
ажиллагаанаас туршлага судлуулахаар
томилон ажиллуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Япон улсын Саппоро хотноо 2025 оны 10 дугаар сарын 02-оос 10 дугаар сарын 07-ны өдрийг дуустал зохион байгуулагдах “Саппоро-2025” олон улсын марафон гүйлтээс туршлага судлуулахаар Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга Мөнхийн Цогзолмааг томилон ажиллуулсугай.

2. Япон улсын “Саппоро-2025” олон улсын марафон гүйлтийн зохион байгуулалт болон үйл ажиллагаанаас сайн туршлага судалж, Улаанбаатар марафон олон улсын гүйлтийн үйл ажиллагаанд нэвтрүүлж өндөр түвшинд зохион байгуулахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (М.Цогзолмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ